



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/383

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Журам батлах тухай” 2018 оны 45 дугаар тогтоолын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), сумдын Засаг даргад тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Ц.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2014 оны
06 дугаар сарын 24-ний өдрийн 1525 дугаар
захирамжийн хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ
СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОСОН АЖ АХУЙН НЭГЖ

Д/д	Сумын харьяалал	Аж ахуйн нэгжийн нэр	Дэлгүүр үйлчилгээний газрын нэр	Байрлал	Худалдаа үйлчилгээний хэлбэр
1	Хөхморьт сум	"Улам төгөлдөр" ХХК	Улам төгөлдөр хүнсний дэлгүүр	Хөхморьт сумын "Цоохор нуур" багийн "Дөргөн нуур"	Худалдах, үйлчлэх